

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр  
Тендер шалгаруулалтын нэр: СБШ 250 өрмийн машины хийн шахуурга, хөргөлтийн блок  
Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/202112003

**“Монголросцветмет” ТӨҮГ** эрх бүхий тендерт оролцогчдоос **СБШ 250 өрмийн машины хийн шахуурга, хөргөлтийн блок** нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000.00 /тавин мянган/** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил буюу 2019, 2020 оны аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 100%-иас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 100 хувиас багагүй байна.**

Тендерийн хамт: **1 880 000** төгрөгийн дүнтэй тендерийн баталгааг ирүүлнэ.

Тендерийг **2020 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 09:00 цагаас өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 09:05 цагт цахим системээр нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Зөвшөөрнө.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98, 508 тоот өрөө, утас:450060+176

**“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ**